



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/108

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны II/04 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Б.Бат-Эрдэнийн Тайвань улсад албан томилолтоор ажиллахад шаардагдах замын зардал 3,095,000 (гурван сая ерэн таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

